



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 519

Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг 9, 15 дугаар зүйлийн 5, "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 26 дугаар заалт, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 183 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

Нэг. Гамшигтай тэмцэх арга хэмжээг нийслэл хотын хэмжээнд удирдан зохицуулах үүрэг бүхий нийслэлийн "Гамшгаас хамгаалах комисс"-ыг нийслэлийн "Онцгой комисс" болгон өөрчилж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгүүдийг хоёрдугаар хавсралтаар, ажиллах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Нийслэлийн Онцгой комисс, түүний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гамшгийн үеийн гүйцэтгэх үүрэгт нь сурган дадлагажуулж, бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /С.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

Гурав. Нийслэлийн нутаг дзэвсгэрт гарч болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшигуулшгүй сэргээн босгох арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусган зарцуулж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/, нийслэлийн Онцгой байдлын газар /С.Цогтбаатар/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Комисс байгуулах тухай" Нийслэлийн Засаг даргын 2005 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 248 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР

0201755
Zab-III

Нийслэлийн Засаг даргын 2005 оны
12 дугаар сарын 13-ны өдрийн
5.19.рүүхр..... захирамжийн
нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Орлогч дарга - Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга
- Гишүүд : - Нийслэлийн Засаг даргын орлогч
- Улаанбаатар хотын Ерөнхий менежер
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн дарга
- Зэвсэгт хүчний жанжин штабын 1 дүгээр орлогч, Улаанбаатар Цэргийн хүрээний дарга
- Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төвийн ерөнхий захирал
- Замын цагдаагийн газрын дарга
- Нийслэлийн Цагдаагийн газрын дарга, Улаанбаатар Цагдаагийн хүрээний дарга
- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Байгаль хамгаалах газрын дарга
- Нийслэлийн Мал эмнэлгийн газрын дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Олон нийттэй харилцах албаны дарга
- Нутаг дэвсгэр дээр нь онцгой байдал үүссэн тухайн дүүргийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга - Нийслэлийн Онцгой байдлын газрын Мэргэжлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Засаг даргын 2005 оны
 12 рунаар сарын 13-өдрийн
 519 рунаар.... захирамжийн
 хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖЛЫН ХЭСГҮҮД

1. Хүч хэрэгслийг нэгтгэн удирдах хэсэг

- | | |
|---------|--|
| Ахлагч | - Нийслэлийн Засаг даргын орлогч |
| Гишүүд: | <ul style="list-style-type: none"> - Зэвсэгт хүчний жанжин штабын 1 дүгээр орлогч, Улаанбаатар цэргийн хүрээний дарга - Нийслэлийн Цагдаагийн газрын дарга, Улаанбаатар Цагдаагийн хүрээний дарга - Замын цагдаагийн газрын дарга - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн дарга - Нийтийн тээвэр, зохицуулалтын газрын дарга - Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга - Нийслэлийн Автозамын газрын дарга - Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга - Нийтлэг үйлчилгээний газрын дарга - Хот төлөвлөлт эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэнгийн захирал - Гамшиг болсон тухайн дүүргийн Засаг даргын орлогч |

2. Үер, хөлдөлтийн үед ажиллах хэсэг

- | | |
|---------|---|
| Ахлагч | - Улаанбаатар хотын Ерөнхий менежер |
| Гишүүд: | <ul style="list-style-type: none"> - Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн ажилтан - Захирагчийн ажлын албаны Хот тохижилтын хэлтсийн дарга - Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын дарга - Ус сувгийн удирдах газрын дарга - "Усны барилга байгууламж " компанийн захирал - Нийслэлийн Газрын албаны дарга -Халаалтын зуухны ашиглалт, зохицуулалтын газрын дарга - "Улаанбаатар дулааны сүлжээ" компанийн ерөнхий инженер - " Улаанбаатар зам засвар арчлалт " компанийн захирал - Гамшиг болсон тухайн дүүргийн Засаг даргын орлогч |

3. Түймэр, хүчтэй салхи шуурганы үед ажиллах хэсэг

- | | |
|---------|--|
| Ахлагч | - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга |
| Гишүүд: | <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Онцгой байдлын газрын орлогч - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга - Хөрөнгө оруулалтын газрын дарга |

- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Байгаль хамгаалах газрын дарга
- Гамшиг болсон тухайн дүүргийн Засаг даргын орлогч

4. Хүн, малын гоц халдварт өвчний үед ажиллах хэсэг

- | | |
|---------|---|
| Ахлагч | - Эрүүл мэндийн газрын дарга |
| Гишүүд: | <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга - Мал эмнэлгийн газрын дарга - Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төвийн ерөнхий захирал - Мэргэжлийн хяналтын газрын Нийгэм, эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга - Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга - Гамшиг болсон тухайн дүүргийн Засаг даргын орлогч |

5. Үйлдвэрийн болон цацраг, химиин ослын үед ажиллах хэсэг

- | | |
|---------|--|
| Ахлагч | - Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга |
| Гишүүд: | <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин дэд бүтцийн хяналтын хэлтсийн дарга - “Улаанбаатар дулааны сүлжээ “ компанийн захирал - ЗАА – ны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга - “Улаанбаатар цахилгаан сүлжээ “ХК –ний захирал - “Гэрэлтүүлэг , чимэглэл “ компанийн захирал - Гамшиг болсон тухайн дүүргийн Засаг даргын орлогч |

Нийслэлийн Засаг даргын 2005 оны
 12 русларын 13-ны өдрийн
 519 зуулж захирамжийн
 гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийслэлийн Онцгой комисс / цаашид “комисс “ гэх / нь нийслэлийн нутаг дэвсгэрт гарсан гамшгийн аюулаас хүн ам, мал ,амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд нутаг дэвсгэрийн гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл хүрэлцэхгүй болж, тухайн дүүргийн удирдлагаас тавьсан хүснэгтийг шуурхай шийдвэрлэх, хүн хүч, техник хэрэгсэл, материалын нөөцийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу дайчлан гаргуулах, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг удирдан зохицуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
2. Комисс нь үйл ажиллагаанд даа Засаг захиргаа ,нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.
3. Нийслэлийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч ,дүүргийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг тухайн дүүргийн Засаг дарга батална.
4. Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг нийслэлийн Онцгой байдлыг газар хэрэгжүүлж, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд данстай байна.
5. Комиссын дарга нь холбогдох хууль, тогтоомж, энэ журмаар олгогдсон үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар тушаал, албан даалгавар, тэмдэглэл гаргана.
6. Комиссоос гаргасан шийдвэрийг орон нутгийн төрийн захиргааны бүх шатны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

Хоёр. Комиссын үүрэг , эрх

7. Комисс нь дараах үүрэгтэй байна .

- 7.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг төр захиргааны орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын шийдвэр, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдаас энэ чиглэлээр тусгайлсан өгсөн үүргийг хэрэгжүүлэх

7.2. Гамшиг бүхий нутаг дэвсгэрийн төр захиргааны байгууллага, албадыг гамшигаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх,хорио цээрийн дэглэм тогтоох талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн санал боловсруулж ,нийслэлийн Засаг даргад оруулан шийдвэрлүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

7.3. Гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх,аврах ,хор уршгийг арилгах, хойшилуулшгүй сэргээн босгох,нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх талаар дүүргийн Онцгой комиссоос зохион байгуулсан ажилд үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай байгаа хүн хүч,техник хэрэгслийн туслалцаа үзүүлнэ. Өөрийн боломжоос давсан асуудлыг Улсын онцгой комисст тавьж шийдвэрлүүлнэ.

7.4.Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга,санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд шуурхай мэдээлэх

7.5.Гамшигийн цагийн байдалтай холбогдуулан байгууллага,иргэдээс гаргасан өргөдөл гомдол,санал хүсэлтийг хүлээн авч барагдуулах ажлыг зохион байгуулах.

7.6. Гамшигийн цагийн байдлын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд , улсын онцгой комисст тогтмол мэдээлж, өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

8. Комисс нь дараах эрхтэй байна:

8.1. Гамшигаас сэргийлэх ажлыг зохион байгуулах,түүний хор уршгийг арилгахтай холбогдсон асуудлаар нийслэлийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа төр, захиргааны болон аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтны сонсгал мэдээллийг хэлэлцэж, үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих.

8.2. Гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх,аврах ,хор уршгийг арилгах, хойшилуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд холбогдох төрийн захиргаан и болон мэргэжлийн байгууллага,албан тушаалтан,аж ахуйн нэгж байгууллага,иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл,хэлбэр үл харгалзан татан оролцуулна.

8.3. Гамшиг гарсан нутаг дэвсгэр, барилга байгууламжинд гамшигаас хамгаалах ажлыг зохион байгуулахаар яваа комиссын гишүүд нь шаардлагатай үед Замын цагдаагийн байгууллагын ажилтанд мэдэгдэж тээврийн хэрэгслийг түр дайчлан гаргуулж,төлбөрийг дараа тооцож ,холбооны хэрэгслийг үнэ төлбөргүй ашиглана

8.4. Гамшигаас урьдчилан сэргийлэх,аврах,хор уршгийг арилгах ажил явуулах үед шаардлагатай машин техникийн баримт бичиг,тодорхойлолт,мэдээ судалгаа бусад материалыг төр захиргааны байгууллага,улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж,,албан тушаалтнаас гаргуулж авах.

8.5. Гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх,тэднийг авран хамгаалах учирсан хор уршгийг арилгах ажилд шаардагдах хүнс ,шатахуун бусад бараа материалыг нийслэлийн нөөцөөс гаргуулах,хөрөнгө зардал олгох асуудлыг хууль тогтоомжийн дагуу холбогдох газарт оруулж шийдвэрлүүлэх

8.6. Гамшгаас урьдчилан сэргийлэх аврах,хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчин болон бусад хүчний байгууллагуудын анги, салбарын бие бүрэлдэхүүн ,тусгай зориулалтын техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дайчлан ажиллуулах

8.7. Гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх,аврах ,хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах нэмэлт зардал болон бараа материал,тоног төхөөрөмжийн тухай асуудлыг Улсын Онцгой комисст тавьж шийдвэрлүүлэх

8.8. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга,санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийх, хэвлэлийн бага хурал зохион байгуулахдаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу оролцуулах

Гурав. Дүүргийн Онцгой комисс

9. Нийслэлийн Онцгой комиссоос баталсан үлгэрчилсэн журмыг үндэслэн дүүргийн Онцгой комиссын ажиллах журмыг дүүргийн Засаг дарга нар батална.

10. Тухай шатны Онцгой комиссын дарга нь Засаг дарга ,уг комиссын орлогч дарга нь дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга байна.

11. Дүүргийн Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ Гамшгийн аюулаас ур. дчилан сэргийлэх,аврах ,хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх,нийслэлийн Онцгой комиссоос өгсөн үүрэг,даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй .

12. Дүүргийн Онцгой комисс нь энэ журмын 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.5, 7.6-д заасан үүргийг биелүүлэн, 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7, 8.8 –д заасан эрхийг эдлэнэ.

13.Дүүргийн Онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ,ур дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр ,авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бурийн 1 дүгээр сард багтаан нийслэлийн онцгой комисст танилцуулна.

Дөрөв. Комиссын зардал

14. Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг нийслэлийн Онцгой байдлын газрын гаргасан тооцоо,нийслэлийн Засаг даргын тамгын газрын санхүү,эдийн засаг,төрийн сангийн хэлтсийн саналыг үндэслэн нийслэлийн Засаг даргаас санхүүжүүлэх бөгөөд тайланг хагас,бүтэн жилээр гарган комиссын гишүүдийн хуралд тайлагнаж байна.

15. Дүүргийн Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх,аврах ,хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө,зардлыг тухайн жилийн төсөвтөө тусган ,зориулалтын дагуу зарцуулна.

Тав. Бусад зүйл

16. Комисс нь ажлын тайлангаа жил бүрийн 1 дүгээр сард багтаан нийслэлийн Засаг даргад танилцуулна.

17. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд захигааны шийтгэл ногдуулах санаалаа комисс эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

18. Комисс нь “Гамшгийн аюулгүйн сан”-тай байна. Сангийн хөрөнгийг комиссын дарга, орлогч захиран зарцуулна.

19. Гамшгийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

-Төв орон нутгийн төсвөөс эрх бүхий байгууллагын шийдвэрээр комиссын мэдэлд шилжүүлсэн мөнгө, хөрөнгө

- Гадаад орон, олон улсын байгууллага, иргэд, түүнчлэн дотоодын аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хандив тусlamжийн мөнгө, хөрөнгө

----- о О о -----